



BASALTWOOL®
МОНГОЛ БАЗАЛЪТ ХК

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 2022

ТОГТВОРТОЙ ИРЭЭДҮЙН ТӨЛӨӨ
ТЭСВЭРТЭЙ ХОТЫГ БҮТЭЭЛЦЭНЭ



А.Энхгэрэл Гүйцэтгэх захирал

Welcome Message

ОХУ болон Украин улс хоорондын цэргийн ажиллагааны нөхцөл байдал болон дотоодын эдийн засгийн хямрал, валютын ханшны савалгаа, инфляцийн өсөлт, тэр дундаа барилга бүтээн байгуулалтын салбарын үйл ажиллагаанд учирч буй хүндрэл бэрхшээлүүдийг даван туулж, оны эхний улирлын дунд үеэс гадаад дотоод үйл ажиллагаагаа эрчимжүүлж эхэлсэн билээ. "Монгол Базальт" ХК-ийн хувьд тайлант хугацаанд ажилтнуудаа тогтвортой ажлын байраар хангах, орлогын эх үүсвэр хангамжийг бууруулахгүй байх бодлогыг нэн тэргүүнд барьж ажилласан юм.

2022 онд зах зээлд гаргасан Монгол Базальт ХК-ийн "ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО"-ын хүрээнд хэрэгжүүлж буй "НОГООН ТӨСӨЛ" бүхий GROWOOL бүтээгдэхүүн нь байгаль орчин, хүнсний үнийн өсөлт, хил гаалиас шалтгаалсан хүнсний хомсдол зэрэг асуудлуудтай бодитой тэмцэх ногоон инноваци юм.

2022 оны 3 дугаар улиралд базальт файбер арматурын үйлдвэрээ ашиглалтанд оруулан шинэ бүтээгдэхүүнээ туршин үйлдвэрлэж, олон нийтэд танилцуулж эхлээд байна.

Цаг үеийн нөхцөл байдалд зохицсон санхүү болон үйлдвэрлэл үйл ажиллагааны оновчтой төлөвлөлт хийн компанийн цаашдын үйл ажиллагааг тогтвортой байлгах бизнес төлөвлөгөөний дагуу үйлдвэрлэл явуулахыг бид нэн тэргүүний зорилгоо болгон ажиллаж үйл ажиллагааны зардлын хэмнэлтийн горимд шилжин, борлуулалтын орлогоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 23.7% өсгөсөн амжилттай ажиллалаа.

Барилгын дулаан тусгаарлагч чулуун хөвөнгийн Үндэсний цор ганц үйлдвэрлэгчийн хувьд бүтээгдэхүүний тоо хэмжээ, төрлүүдээ нэмэгдүүлж үүнийг дагаад санхүүгийн үр дүн үзүүлэлтүүд улам бүр сайжирч хэрэглэгчид болон нийт хувьцаа эзэмшигчидийнхээ хүлээлтийг давуулан биелүүлэх боломж бүрдэнэ гэдэгт итгэлтэй байна.



Бидний тухай

Монгол Базальт ХК нь улсын хөгжлийн түүчээ, эдийн засгийн тэргүүлэх чиглэл бүхий металл бус боловсруулах хүнд үйлдвэрлэлийн салбарт өндөр техник технологийн Евро-стандартын галын аюулгүй байдлыг хангах онцгой тусгаарлагч бүтээгдэхүүний үйлдвэрийг нутагшуулан барилга, дэд бүтэц, эрчим хүчний салбаруудын хэрэгцээг ханган ажиллаж байна.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Оноосон нэр: Монгол Базальт ХК	Байгуулагдсан огноо: 2007	Вэбсайт, фэйсбүүк хаяг: www.basaltwool.mn Mongol Basalt JSC
Үйл ажиллагааны чиглэл: Чулуун хөвөнгийн үйлдвэр, үйлдвэрийн хүчин чадал: Цагт 1.8 тн	Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Фламинго тауэр, 403 тоот	Утас, и-майл хаяг: 75114444 monbasalt@rockwool.mn

УДИРДЛАГА, ХҮНИЙ НӨӨЦ

ТУЗ-ийн дарга: Л.Ариунболд	Гүйцэтгэх захирал: А.Энхгэрэл	Ажилчдын тоо: 80
--------------------------------------	---	----------------------------

ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

Хувьцааны символ код: MSE:MBW / 544	МХБиржид бүртгэгдсэн: 2018.04.05	Нийт гаргасан хувьцаа: 56,417,000 ширхэг	Нээлттэй заралсан хувьцаа: 20,417,000
---	--	--	---

Хаалтын ханш

/2022.12.31/ **186.65₮**


+38.24₮

← **224.89₮**

Өмнөх ханш

/2021.12.31/

Хувьцааны ханшийн график



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

2022 оны 4 сарын 22-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг танхим цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулж, 2021 оны үйл ажиллагааны тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн баталж, 2022 оны бизнес төлөвлөгөөг Хувьцаа эзэмшигчдэд танилцуулсан.

Компанийн засаглал

Монгол Базальт ЖК-ийн хувьд компанийн засаглал гэдэг нь хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг үнэ цэнэтэй, үр өгөөжтэй болгохын тулд нийт Хувьцаа эзэмшигчид, Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/, Гүйцэтгэх удирдлага болон бусад оролцогч талууд хоорондын итгэлцэл, бүхий л харилцаа, үүрэг хариуцлагын зохистой харьцааг тогтооход чухал ач холбогдолтой үйл явц, тогтолцоо юм.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Төлөөлөн удирдах зөвлөл нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай бүтээлч, үр дүнтэй бүтэц юм. Компанийн ТУЗ нь 2022 онд нийт 5 удаа хуралдаж, компанийн үйл ажиллагаатай холбоотой 11 тогтоол, 2 дүгнэлт баталж хэрэгжүүлсэн болно.


ТУЗ-ийн ердийн гишүүд:

- Л.Ариунболд
- П.Сайнбилэг
- Г.Ганзориг
- А.Энхгэрэл
- Б.Шаравсамбуу
- Хан Гю Бунг /Han Kyu Bong/

ТУЗ-ийн хараат бус гишүүд:

- Ш.Энхтөр
- Ч.Зоригтбаатар
- П.Нямдорж

ТУЗ-ийн 2022 оны 11 сарын 21-ний өдрийн 10 дугаартай тогтоолоор компанийн удирдлага, зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн баталсан бөгөөд орон тооны өөрчлөлтийг баталгаажуулан ажиллаж байна.



ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГ



**Гүйцэтгэх захирал
А.Энхгэрэл**
Мэргэжил: Үйлдвэр үйл
ажиллагааны
менежмент,
Санхүү менежмент
Dale Carnegie Mentor
Coach
Harvard Management
Mentor



**Үйлдвэрийн хариуцсан
захирал, Ерөнхий
технологич
П.Баасан-Очир**
Мэргэжил: Технолги
инженер, мэргэшсэн
инженер



**Ерөнхий менежер
Д.Сайнбаатар**
Мэргэжил: Инженер,
эдийн засагч



**Ерөнхий инженер
Х.Батдэлгэр**
Мэргэжил: Цахилгааны
инженер, мэргэшсэн
инженер



**Ерөнхий нягтлан
бодогч
Б.Болортуяа**
Мэргэжил: Нягтлан
бодогч



**Ерөнхий механик
инженер
Ж.Сүхбаатар**
Мэргэжил: Механик
инженер, зураг төслийн
конструктор,
мэргэшсэн инженер



**Дэд захирал
П.Батмөнх**
Мэргэжил: Эрх зүйч




**Дотоод аудитор
Ц.Байгалмаа**
Мэргэжил: Нягтлан
бодогч, Дотоод аудитор

БҮТЭЭГДЭХҮҮН




БАЗАЛЫТ ЧУЛУУН ХӨВӨН

Дуу чимээ, дулаан тусгаарлагч барилгын материал



ТЕРМОБАЗАЛЫТ ШУГАМ ХООЛОЙН ДУЛААЛГА

Яндан турба шугам хоолойн дуу чимээ, дулаан тусгаарлагч материал



БАЗАЛЫТ СЭНДВИЧ ХАВТАН

Дуу чимээ, дулаан тусгаарлагч барилгын материал, 2 талдаа профил төмөртэй чулуун хөвөн хавтан



ГРӨВҮҮЛ

Гидропоник хөрсгүй тариалалт, босоо хүлэмжний технологи, базальт чулуун хөвөн үндэс баригч




ТЕРМОБАЗАЛЫТ ОЁМОЛ ХӨНЖИЛ

Шугам хоолойн дулаалгын материал, дулаан, ус дамжуулах шугам хоолой дулаалахад тохиромжтой



БАЗАЛЫТ ФАЙБЕР АРМАТУР

Базальт фибер арматур ган арматураас 2,5 дахин бэх, 4 дахин хөнгөн



Онцлох үйл явдал /I-р улирал/



Монгол Базальт ХК-ийн философи тогтвортой хөгжлийн зорилтуудтай нягт уялдаа холбоотой. Бид 2022 онд Улаанбаатар хотын гэр хорооллын айл өрхийн ялгаруулж буй нүүрсхүчлийн хий болон агаар орчны бохирдлыг бууруулах дахин дулаалгын төслүүдийг хэрэгжүүлэхэд түлхэц болох ЭСКО зөвшөөрлөө энэ оны эхний улиралд хүлээн авлаа.

ҮЗЭСГЭЛЭН АРГА ХЭМЖЭЭ

Улаанбаатар барилга 2022 үзэсгэлэнд оролцон шинээр хэрэгжүүлж буй арматур, хэсэгчлэн угсрах сэндвич хавтан бүтээгдэхүүний мэдээллийг олон нийтэд танилцууллаа.





"Ногоон хот миний ирээдүй" сэдэвт гар зургийн уралдааныг бага насны хүүхдүүдийн дунд ажилттай зохион байгууллаа.



Монгол Базальт ХК нь тогтвортой хөгжлийн 17 зорилтоос 11-ыг нь эрэмбэлэн манай бизнест хамгийн их ач холбогдолтой, ахиц дэвшил, ололт амжилтыг хэмжих шалгуур болгон ашиглаж байна.

2014 онд гэр хорооллын айлуудын дахин дулаалгын аянууд санаачлан зохион байгуулснаас эхлүүлээд, 2018 онд олон нийтэд танилцуулсан үйл ажиллагааны тайландаа Тогтвортой хөгжлийн бүлэг нэмж оруулан, цаашид олон төсөл хөтөлбөрүүд, арга хэмжээ, дотоод/гадаадын илтгэл танилцуулга бүрийнхээ төвд нь SDG-ийн үзэл баримтлалуудыг гол зорилгоо болгон шингээж ирсэн ба 2022 оны эхний улиралд тогтвортой хөгжлийн тайлан бэлтгэн олон нийтэд танилцуулаад байна.

Цагийн хүрдийн баатрууд-2021: Байгальд ээлтэй үйлдвэрлэл эрхлэгч байгууллагаар Монгол Базальт ХК шалгарлаа.



Онцлох үйл явдал /II-р улирал/

#ХОЖЛЫН_ТӨЛӨӨ_БАГАА_ДЭМЖЬЕ уриан дор АХБХ-НЫ АЗИЙН ЦОМЫН ЭРХИЙН ТӨЛӨӨ ТЭМЦЭЭН-ийг дэмжигч байгууллагаар хамтран ажиллалаа.



ХАМТЫН АЖИЛЛАГАА

GIZ германы түншлэлийн сургалтын хүрээнд тус компанийн гүйцэтгэх захирал А.Энхгэрэл Герман улс дахь чулуун хөвөн ашиглаж буй барилгууд дээр очиж танилцаж, зах зээлийн хэрэглээ, үйлдвэрийн үйл ажиллагааны сургалт семинарт оролцож туршлага солилцлоо.

Франц улсад төвтэй Жэрэс олон улсын төрийн бус байгууллагатай 5000 айл дахин дулаалах төсөл дээр хамтран ажиллах гэрээ байгууллаа.



Шинэ бүтээгдэхүүний туршилт, судалгаа

Монголын Барилгын Материал Үйлдвэрлэгчдийн Холбоо гүйцэтгэх захирал Г.Цэрмаа, "Керамик Урлал" лаборатори, МУ-ын Зөвлөх инженер, ШУТИС-ХШУС докторант Д.Алтанцэцэг, Монгол Базальт ХК гүйцэтгэх захирал А.Энхгэрэл нар **"ХАМТРАН АЖИЛЛАХ, ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ"**-нд гарын үсэг зурлаа.

1. Базальт чулуун хөвөн үйлдвэрлэлийн явцад гардаг хөвөн шлак болон хөвөн үртэсээр ТЕРМОБЛОК хийх, массын найрлага тогтоох туршилт судалгаанд үндэслэн үйлдвэрлэлийн дамжлага цех байгуулж иргэдэд Эрчим хүчний хэмнэлттэй дулаалгатай дүүргэгч ТЕРМОБЛОК бүтээгдэхүүн гаргах
2. Фибрабазальтын туршилт судалгаа, хөндлөнгийн лаборатори шинжилгээ дүгнэлт, массын найрлагын тогтоох туршилт судалгаа хийх
3. Монгол Базальт ХК-ийн залуу технологич Б.Ану болон лабораторын эрхлэгч Г.Мөнхбайгалмаа нарын магистрын ажлыг удирдан зохион байгуулж, хамгаалуулах зэрэг ажлууд гэрээнд тусгагдаж Монгол Базальт ХК санхүүжүүлж ажиллахаар боллоо.



Онцлох үйл явдал / III-р улирал/

ҮЗЭСГЭЛЭН АРГА ХЭМЖЭЭ




НҮБ-аас зохион байгуулж буй “Тогтвортой хөгжлийн зорилго 2022” өдөрлөг SDG Open Day-д оролцож компанийн үйл ажиллагаа, үйлдвэрлэл, бүтээгдэхүүнүүдээ иргэд, олон нийтэд танилцууллаа.



“Барилга орон сууц 2022” үзэсгэлэнд оролцож байраа хэрхэн дулаалах, #BASALTWOOL бүтээгдэхүүний талаар завлэмж сургалтыг хэрэглэгч олон нийтэд хүргэлээ.



ХХААХҮ-ийн яамнаас зохион байгуулсан Eco-Mongolia-2022 үзэсгэлэн арга хэмжээнд оролцож, Грөвүүл хөрсгүй тариалалтын төхөөрөмж, технологийн талаар иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэж ажиллалаа.



“Агаар, орчны бохирдлыг бууруулах ногоон технологи 2022” үзэсгэлэнд оролцож, байшин сууцаа дулаалах гэж байгаа иргэдэд зөвлөгөө мэдээлэл, дулаалгын материалын тооцоолол хийж өглөө.

БАЗАЛТ ФАЙБЕР АРМАТУР ҮЙЛДВЭРИЙН НЭЭЛТ

Монгол Базальт ХК барилга, аж үйлдвэрийн салбарт цоо шинэ технологи, инновацыг нэвтрүүлсэн “БАЗАЛТ АРМАТУР” бүрэн автоматжуулсан үйлдвэрээ 2022 оны 09 сарын 15-ны өдөр нээлээ. Барилга, хот байгуулалтын яамны сайд Б.Мөнхбаатар базальт арматур үйлдвэрийн нээлтэд хүрэлцэн ирж, үйлдвэрийн дээж бүтээгдэхүүнтэй танилцлаа.

30 жилийн судалгаа шинжилгээний түүхтэй манай компани Монголын байгалийн баялаг түүхий эд болох базальт чулуунаас мяндсан нийлэг материалыг гарган авч, төмөр арматураас гурав дахин бат бөх, нягт чанартай арматурыг 100% өөрсдийн инновац, технологийн мэдлэг туршлагаар үйлдвэрлэж эхлээд байна.

Өмнөговь аймгийн ЗДТГ, ИТХ, Хөгжил хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-ын хэрэгжүүлж байгаа “Цэгцтэй гэр хороолол” хөтөлбөрийн хүрээнд орон нутгын барилга угсралт, барилгын материалын худалдаа эрхлэгчид Үндэсний үйлдвэрлэгч Монгол базальт ХК-д зочилж чулуун хөвөн дулаан тусгаарлагч материал болон дулаан эрчим хүчний хэмнэлтийн талаар танилцуулга сургалт авлаа.



Онцлох үйл явдал / IV-р улирал/

ҮЗЭСГЭЛЭН АРГА ХЭМЖЭЭ



Өмнөговь аймгийн Хөгжил хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-ийн хэрэгжүүлж буй цэгцтэй гэр хороолол хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдсан “ХАШААНДАА САЙХАН АМЬДАРЪЯ” үзэсгэлэнд амжилттай оролцлоо.



Монгол Базальт ХК-ийн Гүйцэтгэх Захирал А.Энхгэрэл нь Барилга дэд бүтцийн мэргэжлийн хяналтын Улсын (ахлах) байцаагчдыг чадавхжуулах туршлага солилцох сургалт семинарт уригдан “ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ БА НОГООН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ” сэдвээр сургалт хийлээ



BASALT HOCKEY CUP 2023

Өсвөрийн насны хоккейн улсын аврага шалгаруулах тэмцээнийг Чингэлтэй дүүргийн мөсөн өргөөнд 12 сарын 15, 16-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа.

МОНГОЛ БАЗАЛТ ХК “НОГООН ЭДИЙН ЗАСАГ-НОГООН БИЗНЕС” чуулга уулзалтанд оролцлоо. Энэхүү арга хэмжээнд байгаль орчинд сөрөг нөлөөгүй бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, дэмжигч байгууллагуудын төлөөллүүд оролцож байгаагаараа онцлогтой юм. Арга хэмжээний хүрээнд бизнес эрхлэгчдэд ногоон эдийн засгийн талаар мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, энэ хүрээнд манай улсад хийж буй техник, технологи, цаашдын хөгжил түүний шийдлүүдийн талаар ярилцан, санал солилцлоо.

Цагдаагийн байгууллагын түүхт 101, Мөрдөн байцаах албаны 76 жилийн ойг угтаж хамт олны санаачлагаар ТВ-9 телевизийн “Мөрөөдөл биелдэг” нэвтрүүлгийн уран бүтээлчидтэй хамтран цагдаагийн ахлах ахлагч Э.Батбилэгийн гэр бүлийг шинэ орон сууцтай болгох ажилд оролцлоо.

2022 онд Мишээл сургалтын төвд чулуун хөвөн ашиглан ургамал тариалах гидропоник технологи, тоног төхөөрөмж болон дахин дулаалгын талаар 100-150 хүнд сургалт зөвөлгөө өглөө.



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУД

МОНГОЛ БАЗАЛТ ХК НЬ БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА НҮБ-ЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУДЫГ ХЭРЭГЖҮҮЛЭН АЖИЛЛАЖ БАЙНА

13 ҮҮР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨЙН ҮР НӨЛӨӨЛТ БАГАСГАХ



Нүүрс хүчлийн хий бага ялгаруулах барилга байгууламж, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх

7 СЭРГЭЭГЭЭ ИРНИЙН ӨРЧӨЙН ХӨГЖЛӨӨ



Үйлдвэрийн болон оффисын барилгын фасад засвар шинэчлэл хийж ялгаралыг стандартаас бага хэмжээнд хүргэсэн

13 ҮҮР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨЙН ҮР НӨЛӨӨЛТ БАГАСГАХ



Үйлдвэрийн гарах хоолойн филтер системийг дахин сайжруулж нүүрс хүчлийн хийн ялгаралыг стандартаас бага хэмжээнд хүргэсэн

8 ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР БА ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ



Аюулгүй ажиллагааг сайжруулж, сул зогсолтыг бууруулсан

6 БАТАЛГААТ ҮЙДЭМ ҮС, АРВИН ЭСЭРНИЙ БАГУУЛАМЖААР БАГАСГАХ



Саарал усны нөөцийн дахин хэрэглээг нэвтрүүлж үйлдвэрийн усны хэрэглээг дахин боловсруулалтад оруулсан

9 АЖ ҮЙДЭВЭР ҮЙНЭВЭЛ, ЭХЭ БИТЭМЭГ ЗӨГЖӨӨХ



Бат бөх, галд тэсвэртэй барилга байгууламжийг нэмэгдүүлэх

8 ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР БА ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ



Тогтвортой ажлын байр, эдийн засгийн өсөлтийг дэмжих

13 ҮҮР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨЙН ҮР НӨЛӨӨЛТ БАГАСГАХ



Нүүрсөрөгчийн хэмнэлттэй барилга байгууламж, үйлдвэрлэлийг идэвхжүүлэх

11 ДЭЛЭЙН НОТ АЖИЛЛАХ ӨРЧӨЙН ХӨГЖЛӨӨ



Оролгод нийцсан орон сууц, эрчим хүчний хэмнэлтийг дэмжих

7 СЭРГЭЭГЭЭ ИРНИЙН ӨРЧӨЙН ХӨГЖЛӨӨ



Эрчим хүчний хэмнэлттэй барилга үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх

ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭРЭГЛЭЭ

12 ЗАРИУЦЛАГААЙ ХӨРГӨӨХ ҮЙЛДЭВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ



Уур амьсгалын өөрчлөлт, түүний сөрөг нөлөөллийг багасгах арга хэмжээг яаралтай авах

3 ЭРГЭЛ НЭЭДИЙГ ДЭМЖИХ



Дуу чимээний тусгаалттай барилга байгууламжийг нэмэгдүүлэх

6 БАТАЛГААТ ҮЙДЭМ ҮС, АРВИН ЭСЭРНИЙ БАГУУЛАМЖААР БАГАСГАХ



Тариалтын усны хэрэглээг багасгах

2 ӨСӨЛТӨЙН ЗӨГЖӨӨ



Тогтвортой хүнсний үйлдвэрлэлийг бий болгох

НОГООН ТӨСӨЛ GROWOOL



Чулуун хөвөн ашиглан гидропоник технологиор тариалалт хийх нь байгаль цаг уураас хараат бус жилийн дөрвөн улирал тогтвортой ургац хураах боломжыг бүрдүүлэх болно.

Монгол Базальт ХК-ийн хамт олон анхны монгол хэл дээрх хөрсгүй тариалалтын гидропоник технологийн зааварчилгаа, гарын авлага номыг бэлтгэн, 2021 онд худалдаанд гаргасан.

Монгол Базальт ХК нь 2019 оноос GROWOOL /ургамал тарих чулуун хөвөн/ старт апыг бойжуулан хадгалалт тээвэрлэлтээс үүсэх хүнсний ногооны хаягдалыг багасгах, усны хэрэглээ бага тариалалтын технологийг нэвтрүүлэх, хуурай сэрүүн уур амьсгалтай Монгол орны нөхцөлд байгаль цаг уураас хараат бус жилийн турш тогтвортой тариалалт хийх боломжтой гидропоник технологийн талаар сургалт зөвөлгөө, гарын авлага, мэдээлэлийг иргэд аж ахуй нэгж, нийгэмд түгээн ажиллаж байна.

2022 оны 07 сард GROWOOL start up хөгжүүлэлтийн багийнхан GLOBAL VERTICAL FARMING SHOW GVF 2022 эрдэм шинжилгээний хуралд оролцон Дэлхийн Босоо ухаалаг хүлэмж хөгжүүлэгч мэргэжлийн эрдэмтэн инженерүүдийн конференцид тавьсан илтгэлүүдийг сонсож санал бодлоо хуваалцаж туршлага судаллаа.



Тогтвортой хүнсний үйлдвэрлэл

Монгол улсын хүнсний ногооны 80%-г импортын бүтээгдэхүүн эзлэж байна. COVID-ын нөлөөгөөр монгол улсад өргөн хэрэглээний хүнсний ногооны үнэ нэмэгдэж, хомсдол бий болж буй энэ цаг үед бид иргэн бүр хүнсний ногоогоо өөрөө ургуулах боломжтойг сурталчилан таниулж байна.

Монгол улсын цэвэр усны хэрэглээний 12%-г усалгаатай тариалан буюу газар тариаланд ашигладаг бөгөөд базальт чулуун хөвөн ашигласнаар газар тариаланд ашиглаж буй усыг 80-90%, тариалалтын талбайн хэмжээг 70% хүртэл бууруулах бүрэн боломжтой юм.

Мөн жилийн дөрвөн улиралд уур амьсгал, цаг агаарын нөлөөлөлөөс шалтгаалахгүйгээр тогтвортой хүнс үйлдвэрлэх боломжтой тул тогтвортой хөгжлийн зорилтын 2, 6 болон 15 дугаар зорилтуудыг бүрэн хангаж чадсан **НОГООН** төсөл юм.

2 ӨЛСГӨЛӨНГ
ЗОГСООХ



6 БАТАЛГААТ УНДНЫ УС
АРИУН ЦЭВРИЙН
БАЙГУУЛАМЖААР
ХАНГАХ



15 ХУУРАЙ ГАЗРЫН
ЭКО СИСТЕМИЙГ
ХАМГААЛАХ



ХҮНИЙ НӨӨЦ




2019-2022 оны хооронд тогтвортой ажлын байрны өсөлт 20% байгаа бөгөөд шинээр файбер арматурын үйлдвэр ашиглалтанд оруулж ажлын байрны тоо хэмжээ өссөн үзүүлэлттэй байна. Нийт ажилтаны 90% нь дээд боловсролтой, 70% нь 3 жилээс дээш хугацаанд ажилласан нь хүний нөөцийн тогтвортой, чадварлаг баг бүрдсэнийг илтгэж байна. 35-аас доош насны шинэ залуу инженер техникийн ажилчдыг бүрдүүлж, эх орондоо ажиллах, хөдөлмөрлөх боломжийг олгодог.


Боловсролын түвшин /%/




Ажилласан жил /%/



Сарын дундаж цалингийн сан 2018-2022 он /сая.төг/



Ажиллах хүчний харьцуулалт 2019-2022 он



ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТАЙЛАНГИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ШУТИС БАС-ЫН ОЮУТНУУДАД ҮЙЛДВЭРЭЭ ТАНИЛЦУУЛЛАА.



Эрдэнэт үйлдвэрийн дулааны цахилгаан станцын 30 жил болсон дулаан дамжуулах шугамын дулаалгын ажлыг Термобазальт ХХК-тай хамтран хийж гүйцэтгэлээ.



2022 онд 2000 цаг ажиллаж, 1770 цаг хөвөн гаргаж нийт **3186,5** тонн буюу 250,000 боодол хөвөн үйлдвэрлэлээ.

Оёмол хөнжлийн хэсэгт Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийн Дулааны цахилгаан станц, Бумбод ХХК, Мабетекс Монголиа ХХК-уудын захиалгаар нийт **4589** метр базальт файбер утсан торон гадаргуутай хуйлмал хөнжил бэлтгэн нийлүүлээ.

Термобазальт ХХК-д нийт 4527 метр шугам, яндан хоолой үйлдвэрлэх базальт чулуун хөвөнг нийлүүлэн ажиллаа.

Технологийн алба ХАБЭАА-тай хамтран Хувийн хамгаалах хэрэгсэл, үйлдвэрийн ослын талаарх сургалтыг **5** удаа зохион байгуулж, нийт ажилчдыг хамрууллаа.




БОРЛУУЛАЛТ



Монгол Базальт ХК нь 2022 онд зах зээлийн эрэлт хэрэгцээг бүрэн хангах зорилгоор их бүтээн байгуулалтыг өрнүүлж үйлдвэрлэлийн шугам дамжлагаа хүчитгэн ажилласаны үр дүнд 217,000 боодол бүтээгдэхүүн борлуулсан байна.

Нийт борлуулсан бүтээгдэхүүний 33%-ийг базальт лайт, 19%-ийг базальт хауз, 34%-ийг базальт вент фасад, 14%-ийг базальт техно марк тус тус эзэлж байна.

Борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ /улиралаар/



Хувьцааны мэдээлэл



ХУВЬЦААНЫ ХАНШ

Тайлант хугацаанд хоёрдогч зах зээлд арилжаалагдсан нийт хувьцааны дээд ханш нь 239.0₮, доод ханш нь 172.19₮ бөгөөд 2022 оны хаалтын ханш 224.89₮ байлаа.

Тайлант хугацаанд үнэт цаасны хоёрдогч зах зээлд 1829.7 мянган ширхэг буюу тайлант хугацааны туршид нийт 379.4 сая төгрөгөөр арилжаалагдлаа.

Хувьцаа эзэмшигчид

5%-иас дээш хувьцаа эзэмшигчид:

№	Нэр	Хувьцааны тоо	Нийт хувьцаанд эзлэх хувь
1	Л.Ариунболд	20,140,896	35.7%
2	П.Сайнбилэг	7,503,461	13.3%
3	А.Энхгэрэл	3,949,190	7%
4	А.Энхмаа	3,949,190	7%
5	А.Энхжин	3,949,190	7%


САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАНГИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД




Монгол Базальт ХК нь 2022 оны тайлант хугацаанд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж зах зээлийн эрэлт хэрэгцээг бүрэн хангахын сацуу их бүтээн байгуулалтыг өрнүүлэн Базальт файбер арматурын үйлдвэрийн шугамыг ашиглалтанд оруулж базальт арматур бүтээгдэхүүнээ зах зээлд нийлүүлж эхлээд байна.

Борлуулалтын орлого өмнөх оны мөн үеэс 2.7 тэрбум төгрөгөөр буюу 23.7% өсөлттэй байна.

Борлуулалтын орлого IV-улирал /сая.төг/




Цэвэр ашиг / борлуулалтын орлогод эзлэх хувиар/



Олгосон ногдол ашиг

Он	Нийт ногдол ашиг	Цэвэр ашигт эзлэх %	Нэгж хувьцаанд ногдох /₮/	Ногдол ашгийн өгөөжийн %
2019	225,668,000.00	68%	4.00	2%
2020	162,480,960.00	100%	2.88	2%
2021	964,166,530.00	60.2%	17.09	10%
2022	1,128,340,000.00	53.4%	20	9%

Ногдол ашгийн өсөлт



2022 оны 12 сард хувьцаа эзэмшигчдийн дансанд 2021 оны ногдол ашиг болох нийт 964,166,530 төгрөгийг олголоо.

2022 оны жилийн эцсийн байдлаар нийт борлуулалтын орлогын 14.5% буюу 2.06 тэрбум төгрөгийн татварын дараах цэвэр ашигтайгаар ажилласан нь зах зээлийн эрэлт нийлүүлэлтийг тасралтгүй ханган, үйлдвэрлэлийг зардлын удирдлагын оновчтой менежментээр удирдан зохион байгуулсаны үр дүн юм.

Тайлант хугацаанд нийт богино хугацаат өр төлбөрийг 3 дахин бууруулж, 3,031.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

Монгол Базальт ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд

Аудиторын дүгнэлт

Бид Монгол Базальт ХК (цаашид “Компани” гэх)–ийн 2022 оны 12 дугаар сарын 31–ний өдрөөрх Компанийн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон үеийн жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2022 оны 12 дугаар сарын 31–ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон үеийн санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (“СТОУС”)–ын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (“АОУС”)–уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн “Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага” хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан “Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм”–ийн дагуу Компаниас хараат бус бөгөөд уг дүрэмд заасны дагуу өөрсдийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Санхүүгийн тайлантай холбоотойгоор удирдлагын хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС–ын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтуудад удирдлага хариуцлага хүлээнэ.

Компанийн удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Компанийн үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага нь тасралтгүй байх зарчмын дагуу Компанийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй.

Компанийн удирдлага нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Санхүүгийн тайлантай холбоотойгоор аудиторын хүлээх үүрэг

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу тайлагналуудаас санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Зохистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч “АОУС”–ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу тайлагналуудыг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу тайлагналууд нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.



ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Санхүүгийн тайлантай холбоотойгоор аудиторын хүлээх үүрэг (үргэлжлэл)

АОУС-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэнд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлттэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)–ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг Компанийн удирдлагад мэдэгддэг.

Бусад зүйл

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор бус, Монгол Улсын "Компанийн тухай хууль"–ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Компанийн хувьцаа эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК

Мэргэшсэн нягтлан бодогчид



Э.Булган
Партнер

Улаанбаатар хот, Монгол улс
2023 оны 3 дугаар сарын 13-ны өдөр

МОНГОЛ БАЗАЛЫТ ХК

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

(Мянган төгрөгөөр)	Тод	2022-12-31	2021-12-31
ХӨРӨНГӨ			
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	14	1,428,327	5,964,105
Дансны авлага	15	323,207	4,887
Бусад авлага	16	546,252	114,198
Бараа материал	17	3,940,040	2,425,087
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	18	1,328,046	653,898
Нийт эргэлтийн хөрөнгө		<u>7,565,872</u>	<u>9,162,175</u>
Үндсэн хөрөнгө	19	16,848,678	15,562,795
Биет бус хөрөнгө	20	10,721,366	13,503,921
Нийт эргэлтийн бус хөрөнгө		<u>27,570,044</u>	<u>29,066,716</u>
НИЙТ ХӨРӨНГӨ		<u><u>35,135,916</u></u>	<u><u>38,228,891</u></u>
ӨР ТӨЛБӨР			
Дансны өглөг	21	342,516	181,382
Бусад өглөг	22	4,147	131,729
Орлогын татварын өглөг	23	113,842	244,634
Бусад татварын өглөг	24	773,968	859,869
Богино хугацаат зээл	25	1,957,000	5,900,142
Урьдчилж олсон орлого	26	1,171,490	1,054,623
Нөөц өр төлбөр	27	741,788	180,328
Нийт богино хугацаат өр төлбөр		<u>5,104,751</u>	<u>8,552,707</u>
Урт хугацаат зээл		-	-
Нийт урт хугацаат өр төлбөр		<u>-</u>	<u>-</u>
НИЙТ ӨР ТӨЛБӨР		<u><u>5,104,751</u></u>	<u><u>8,552,707</u></u>
ЭЗДИЙН ӨМЧ			
Хувьцаат капитал	28	5,641,700	5,641,700
Нэмж төлөгдсөн капитал	28	20,509,765	20,509,765
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	20	1,429,274	1,429,274
Хуримтлагдсан ашиг	28	2,450,426	2,095,445
НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ		<u>30,031,165</u>	<u>29,676,184</u>
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		<u><u>35,135,916</u></u>	<u><u>38,228,891</u></u>

МОНГОЛ БАЗАЛЫТ ХК

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН
АШИГ, АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

(Мянган төгрөгөөр)	Тод	2022	2021
Борлуулалтын орлого	6	14,212,925	11,485,330
Борлуулалтын өртөг	7	(10,268,992)	(7,488,969)
Нийт ашиг		<u>3,943,933</u>	<u>3,996,361</u>
Бусад орлого	8	3,763	3,373
Бусад олз/гарз	9	118,090	2,139
Борлуулалт, маркетингийн зардал	10	(874,050)	(733,235)
Ерөнхий ба удирдлагын зардал	11	(772,902)	(694,762)
Бусад зардал	12	(17,604)	(287,401)
Үйл ажиллагааны ашиг		<u>2,401,230</u>	<u>2,286,475</u>
Хүүний орлого	13	9,465	77,088
Санхүүгийн зардал	13	(213,115)	(507,236)
Татварын өмнөх ашиг		<u>2,197,580</u>	<u>1,856,327</u>
Орлогын татварын зардал	23	(213,066)	(254,262)
ЦЭВЭР АШИГ		<u>1,984,514</u>	<u>1,602,065</u>
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	20	-	1,429,274
Бусад дэлгэрэнгүй орлого		-	1,429,274
НИЙТ ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГО		<u>1,984,514</u>	<u>3,031,339</u>
Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (төгрөгөөр)		35.18	53.73



 **Address**

УБ хот, БГД, 20-р хороо, үйлдвэрийн
тойруу-132 тоот

 **Telephone**

+976 75114444

 **Website**

www.Basaltwool.mn